

Таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөл

Хилийн процедурын тухай мэдээлэл

Та яагаад энэ товхимолыг хүлээж авав?

Та Нидерландын Вант улсын хилээр агаарын ба усан замын боомтоор орж ирлээ. Тэгээд та одоо энд дүрвэгсдийн орогнол хүсэх өргөдөл өгөхийг хүсэж байна. Дүрвэх гэдэг нь: эх орондоо аюул заналд учирсан хүмүүс өөрийн эх орноосоо хамгаалалт авч чадахгүйн улмаас өөр улсаас хамгаалалт хүсэхийг хэлнэ.

Хэрвээ та дүрвэгсдийн орогнол асууж өргөдөл өгвөл, Нидерландын Вант улсын засгийн газраас албан ёсоор оршин суух зөвшөөрөл асууж байна гэсэн үг юм. Нидерландын Вант улсад амьдрахад танд зөвшөөрлийн бичиг баримт хэрэгтэй. Таныг дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлөө өгсний дараа дүрвэгсдийн процедур эхэлнэ: энэ нь Нидерландын Вант улсын засгийн газар танд оршин суух зөвшөөрлийн бичиг өгөх эсэхийг шийддэг хууль эрх зүйн үйл ажиллагаа юм. Таны дүрвэгсдийн өргөдөл Хилийн процедурын дагуу шийдэгдэнэ. Хилийн процедур нь хамгийн удаандаа 28 хоног үргэлжилж дуусна.

Энэ товхимолоос та Хилийн дүрвэгсдийн процедур хэрхэн явагддаг тухай унших болно. Мөн таны хийх ёстой (таны үүргүүд) ба та Нидерландын Вант улсын засгийн газраас юуг хүсэмжилж болох (таны эрхүүдийн) тухай уншаарай.

1 дүгээр алхам: ирснээ мэдэгдэх ба бүртгүүлэх

Та Нидерландын Вант улсын хилийн хамгаалалтын албанд ирснээ мэдэгдэнэ. Энэ нь ихэнхдээ Koninklijke Marechaussee – (Хааны Цагдаагийн Албанд) байдаг. Хааны Цагдаагийн Албаны ажилтнууд таны хувийн мэдээллийг тодорхойлдог. Тэд таны овог нэр, төрсөн он сар ба иргэншлийг бүртгэдэг. Тэд мөн таны хувцас ба ачаа тээшийг шалгаж, зураг болон хурууны хээг тань авдаг. Таны хурууны хээг авах болсон шалтгааны талаар танд товхимол өгсөн байгаа. Та дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлдөө гарын үсгээ зурна.

Таны туулсан аян замын тухай, урьд өмнө нь та эндээс болон өөр бусад Европын орнуудаас дүрвэгсдийн орогнол асууж байсан эсэх, энд болон өөр бусад Европын орнуудад таны төрөл садангууд амьдардаг эсэхийг танаас мөн асуух болно.

Танд өөрийгөө хэн болохыг нотлох бичиг баримт, паспорт, иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ юмуу жолооны үнэмлэх байна уу? Эсвэл танд туулсан аян замын болон дүрвэх болсон түүхээ нотолсон бичиг баримтууд жишээ нь онгоцны билет, тийз, дипломууд, шүүхийн шийдвэр ба сонингийн нийтлэл байна уу? Энэ бичиг баримтуудаа бүртгүүлэх үедээ өгөх юмуу эсвэл дүрвэгсдийн процедураа эхлэхээс өмнө олж бүрдүүлнэ үү. Хаалттай дүрвэгсдийн байрны VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтан таны энэ ажилд тусалж чадна.



VluchtelingenWerk Nederland – Нидерландын ДүрвэгсдийнАжил бол биеэ даасан хүний эрхийг хамгаалах байгууллага бөгөөд дүрвэгсдийн эрх ашгийг хамгаалахын тулд байгуулагдсан юм. VluchtelingenWerk ДүрвэгсдийнАжил танд болон дүрвэгсдийн процедурын тухай тайлбар ба мэдээлэл өгдөг. Таныг процедураа туулахад, хувийн мэдээллийг тань лавлаж өгөх ба өөр байгуулгуудтай үүссэн асуудлуудыг тань зохицуулж өгөхөд VluchtelingenWerk тусалдаг. Тэд энэ үйл ажиллагаандаа таны өмгөөлөгчтэй хамтран ажилладаг. VluchtelingenWerk таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд шийдвэр гаргахгүй.

Таны бичиг баримтуудын жинхэнэ эсэхийг Хааны Цагдаагийн Албаны мэргэжилтэнүүд шалгадаг. IND таны дүрвэгсдийн асуудлыг дүгнэж шийдэхдээ энэ бичиг баримтуудыг ашигладаг.

Анхаар! Таны хувийн мэдээлэл ба таны бичиг баримтууд дүрвэгсдийн асуудлыг шийдэхэд чухал нөлөө үзүүлдэг. Өгч буй мэдээлэл тань бүрэн гүйцэд мөн зөв бичигдсэн эсэхийг шалга. Хувийн бичиг баримтаа хэзээ ч битгий хая.

Нидерландын Вант улс таны эх орны засаг захиргаанд таныг Нидерландын Вант улсад орогнол асуусан гэж хэзээ ч мэдэгдэхгүй.

2 дахь алхам: амрах ба бэлтгэлээ хангах хугацаа

Дүрвэгсдийн процедур таныг Нидерландын Вант улсад ирэнгүүт шууд эхэлдэггүй. Эхлээд танд зургаан хоногийн аян замын алжаалаа тайлах ба дүрвэгсдийн процедуртаа бэлдэх хугацаа олгодог. Энэ хугацааг амрах болон бэлтгэлийн хугацаа(RVT) гэж нэрлэдэг. Өмгөөлөгчтэйгөө зөвшилцсөний дараа энэ хугацааг богиносгож өгөхийг IND – гэс хүсэж бас болдог.

Байр

Та ирснээ мэдэгдэж, бүртгүүлсний дараа хэдэн цагийн дотор таныг Schiphol (Шхипхол)-ын ойрлоо хаалттай орогнох байранд хүргэж өгдөг. Та дүрвэгсдийн процедур үргэлжлэх хугацаандаа энэ төвд байрлах болно. Энэ байрыг та өөрийн мэдлээр орхин гарч явж болохгүй. Энэ барилга дотор Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлийг Хариуцсан Байгууллага (IND) – гийн байр байдаг.



Immigratie- en Naturalisatiedienst
Ministerie van Veiligheid en Justitie

Immigratie- en Naturalisatiedienst (IND) – Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага нь Нидерландын Вант улсын Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яамны харъяа байгууллага юм. IND-гийн ажилчид чамайг хэн болох, чиний иргэншил харъяалал, ирэхдээ туулсан зам, эх орноосоо дүрвэн гарсан шалтгааны тухай таньтай ярилцдаг. Тэгээд тэд чиний хувийн түүхийг болон эх орны чинь нөхцөл байдлыг судалдаг. Дараа нь тэд чамайг Нидерландын Вант улсад (түр хугацаанд) үлдэж болох эсвэл өөр Европын орон луу буцаах ёстой эсэхийг шийдвэрлэдэг.

Сүрьеэ өвчний үзлэг

Сүрьеэ бол маш аюултай, дэлхийд ихээр тархсан өвчин юм. Магадгүй таны амьдарч байсан оронд ч байж болзошгүй. Онгорхой сүрьеэтэй хүмүүс өөр бусад хүмүүст жишээ нь хайнааж, найтаах замаар өвчнөө түгээх аюултай.

Хаалттай дүрвэгсдийн байрны Эрүүл мэндийн төвийн ажилтан танд энэ өвчинтэй холбогдолтой асуултууд тавина. Хэрвээ таныг сүрьеэтэй байх боломжтой гэж үзвэл танд сүрьеэгийн бүрэн шинжилгээ хийнэ. Үүний тулд таныг эмнэлэг рүү аваачдаг. Хэрвээ та сүрьеэтэй бол таныг Нидерландын Вант улсад эм өгч эмчилдэг. Энэ тохиолдолд дүрвэгсдийн процедур эмчилгээний дараа эхэлнэ.

Мэдээлэл

VluchtelingenWerk– (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтан танд мэдээлэл, зөвлөгөө өгөхөөс гадна таны дүрвэгсдийн процедурын үеэр танд тусалдаг.

VluchtelingenWerk– (ДүрвэгсдийнАжил) байгууллагын үйлчилгээ үнэгүй байдаг. Тэд таны мэдээллийн хувийн нууцыг чандлан хадгалж ажилладаг.



FMMU - Дүрвэгсдийн төвд танд Forensisch Medische Maatschappij Utrecht – Шүүх Эмнэлгийн Эрүүл мэндийн Эмгэг судлалын Утрэхтийн Төвийн сувилагчтай уулзах цаг өгнө. Энэ сувилагч танаас эрүүл мэндийн үзлэгт орох уу гэж асууна. Энэ үзлэгийн зорилго нь танд сэтгэл мэдрэлийн ба/ эсвэл бие махбодийн ямарваа өвчин эмгэг буй эсэх, энэ эмгэг нь таны IND-д өгөх ярилцлагуудад нөлөө үзүүлэх эсэхийг судална.

Эрүүл мэндийн зөвлөгөө

Энэ үзлэгт сувилагч танаас асуултууд асууна. Хэрвээ шаардлагатай гэж сувилагч үзвэл таныг нарийвчилсан шинжилгээнд оруулахаар эмч рүү шилжүүлдэг. Гарсан шинжилгээний хариуг сувилагч юмуу эмч зөвхөн таныг хүсвэл IND-рүү илгээдэг. IND таны дүрвэгсдийн процедурын үеэр таны эрүүл мэндийн асуудлыг харгалзан үздэг.

Та сэтгэл мэдрэлийн ба биеийн зовиураа шударгаар сувилагчид юмуу эмчид ярих нь их чухал юм. Хэрвээ танд шарх сорви байгаа бол үүнийг сувилагчид хэлээрэй. Эрүүл мэндийн шинжилгээний хариу бол хувийн нууц. Эрүүл мэндийн шинжилгээг хүн бүр өгөх албагүй. Та эрүүл мэндийн шинжилгээнд мөнгө төлөхгүй.

Хэрвээ та Эрүүл мэндийн шинжилгээ өгөх хүсэлгүй бол сувилагчид мэдэгдээрэй. Энэ тохиолдолд IND таны дүрвэгсдийн процедурын үеэр таны эрүүл мэндийн асуудлыг харгалзан үзэж чадахгүй.

Өмгөөлөгчийн тусламж

Та дүрвэгсдийн процедурын үеэр өмгөөлөгчийн тусламж авна. Энэ өмгөөлөгч нь Нидерландын Вант улсын засгийн газарт хамааралгүй биеэ даасан хүн байдаг. Өмгөөлөгчтэйгөө уулзах үеэр өмгөөлөгч таныг IND - д өгөх ярилцлагад бэлддэг. Энэ бэлтгэл ярилцлага таны байгаа барилга дотор явагддаг.

Raad voor Rechtsbijstand *legal aid*

Raad voor Rechtsbijstand (Legal Aid) - Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар таныг өмгөөлөгчийн тусламж аваад зардлыг нь төлж чадахгүй тохиолдолд тусалдаг. Өмгөөлөгчийн танд үзүүлсэн үйлчилгээний хөлсийг Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар өмгөөлөгчид төлдөг. Өмгөөлөгч бол Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газрын ажилтан биш юм. Өмгөөлөгч бол таны дүрвэгсдийн процедурт туслалцаа үзүүлэх биеэ даасан хууль эрх зүйн тусламж үзүүлэгч юм.

Өмгөөлөгчийн үйлчилгээнд мөнгө төлөх шаардлагагүй. Таны мэдээллийн нууцыг тэд хадгалж ажиллах ёстой.

3 дахь алхам: Дүрвэгсдийн процедур өдөр өдрөөр

Таны дүрвэгсдийн процедур амрах болон процедуртаа бэлдэх хугацаа дууссаны дараа эхэлдэг. Таны байршиж байгаа барилга дотор дүрвэгсдийн процедур үргэлжилдэг. Өмгөөлөгчийн ярилцага ч энд явагдана. Энэ барилга дотор өмгөөлөгч болон IND тус бүрийн өрөөнүүдтэй байдаг.

Таны дүрвэгсдийн процедур өдрөөс өдөрт хэрхэн явагддаг талаар үргэлжлүүлэн энэ доороос уншиж болно.

1 дэх өдөр: анхны ярилцлага

Та IND-гийн ажилтанд өөрийгөө хэн болох, иргэншил харьяалал, ирэхдээ туулсан замынхаа талаар албан ёсны ярилцлага өгнө. Энэ ярилцлагыг нэгдүгээр ярилцлага гэж нэрлэдэг. Энэ ярилцлаганд таны дүрвэх болсон шалтгааны тухай асуултууд асуухгүй. Тэр талаар дараа нь IND-гийн ажилтантай хийх ярилцлагын үеэр авч хэлэлцдэг(өдөр 3-ыг харна уу).

IND-гийн ажилтан таныг хэн болохыг, иргэншил харьяалал, ирэхдээ туулсан замын тухай тодорхой мэдэхийн тулд эсвэл таныг үнэн ярьсан эсэхийг шалгахын тулд маш их нарийвчилж асуултууд асууна. Та энэ ярилцлагадаа аль болох сайн бэлдээрэй. Танд өөрийгөө хэн болох талаар ойлгомжтой, бүрэн бүтэн тайлбарлаж ярих ганцхан боломж олдож байна. Хуурамч (аялалын)бичиг баримтынхаа нэр өгөгдлийг биш харин үргэлж өөрийнхөө жинхэнэ мэдээллийг өгөөрэй.

Хэрвээ та өөр (=нууц нэр) нэр хэрэглэж байсан бол тэрийгээ бас хэлээрэй. Таны бичиг баримтууд болон ярьсан түүх намтрын чинь жинхэнэ үнэн эсэх нь шалгагддаг. Хэрвээ IND таны түүхийг худлаа юмуу бичиг баримтуудыг чинь хуурамч гэж тодорхойлбол таны орогнол хүссэн өргөгдөл сөргөөр нөлөө үзүүлэх боломжтой. Хэрвээ та хүсвэл VluchtelingenWerk-ДүрвэгсдийнАжил байгууллагыг анхны ярилцлагадаа хамт байлгахгаар асууж болно. VluchtelingenWerk-ДүрвэгсдийнАжил байгууллага нь таны чухал бичиг баримтуудыг гадаадаас авчруулахад тусалж чадна.

IND-тэй ярилцах ярилцлагад хэлмэрч байх болно. IND -гийн ажилтан Нидерланд хэлээр асуултууд асууна. Хэлмэрч тэдгээр асуултуудыг таны ойлгодог хэл рүү хөрвүүлнэ. Хэлмэрч мөн таны хариулсан хариултуудыг Нидерланд хэл рүү хөрвүүлнэ. Хэлмэрч бол биеэ даасан хүн бөгөөд таны дүрвэгсдийн процедурын асуудлыг шийдэхэд нөлөө үзүүлэхгүй. Хэрвээ хэлмэрч та хоёр бие биенээ сайн ойлголцохгүй байгаа бол та мэдэгдээрэй. IND танд өөр хэлмэрч олж өгнө. Та асуултаа сайн ойлгоогүйгээс болоод буруу ойлголт үүсэхгүй байх нь чухал юм. Хэрвээ та нөхөр/эхнэртэйгээ буюу хамтран амьдрагчтайгаа хамтдаа орогнол асууж өргөгдөл өгсөн бол, та бүхэн тус тусдаа IND-гийн ажилтанд ярилцлага өгнө. Та (өмгөөлөгчөөрөө дамжуулан) анхны ярилцлагын тайланг хүлээн авна.

2 дахь өдөр: дараагийн гүнзгийрүүлсэн ярилцлагадаа бэлдэх

Та өмгөөлөгч таньтай анхны ярилцлагын тайлангийн тухай хэлэлцэнэ. Хаалттай дүрвэгсдийн байранд өмгөөлөгчтэй ярилцахад зориулагдсан тусгай өрөө байх болно. Энэ ярилцлагын үеэр өмгөөлөгч болон танд орчуулж туслах хэлмэрч байх болно. Хэрвээ тайланд дутуу бичигдсэн ба алдаатай зүйлс байвал өмгөөлөгч бичгээр IND-д мэдэгддэг. Таны өмгөөлөгч таныг IND –тэй хийх хоёр дахь ярилцлагад бэлдэнэ.

3 дахь өдөр: гүнзгийрүүлсэн ярилцлага

IND-тэй хийх хоёр дахь ярилцлагыг гүнзгийрүүлсэн ярилцлага гэж нэрлэдэг. Энэ ярилцлагад та дүрвэх болсон шалтгаанаа ярина. Энэ ярилцлагын үеэр IND-гийн ажилтан танаас асуултууд асуух болно.

Танд яагаад хамгаалалт хэрэгтэй байгаа бүх учраа ярих нь их чухал юм. Танд юу тохиолдсон болон ямар шалтгаанаар та эх орноосоо хамгаалалт авч чадахгүй байгаагаа та шударгаар, бүрэн гүйцэд, ойлгомжтой яриарай. Хэрвээ та ямар нэгэн болсон үйл явдлыг сайн санахгүй байгаа бол IND-гийн ажилтанд тайлбарлаж хэлээрэй. IND-гийн ажилтан таны эх орны нөхцөл байдлын талаар ерөнхий ойлголттой байгаа. Та өөрийнхөө хувийн нөхцөл байдлын талаар ярих нь чухал юм: Ер нь яагаад танд хувь хүний хувьд хамгаалалт хэрэгтэй байгаа юм бэ. Та аль болох түүхтэйгээ хамааралтай мэдээллийг нарийвчилж ярих хэрэгтэй. Хэрвээ танд таны дүрвэх болсон шалтгаантай холбоотой шарх сорви, бие махбодийн болон сэтгэл санааны зовуурь байгаа бол үүнийгээ IND-гийн ажилтанд хэлж байх нь чухал юм. Хэрвээ IND таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөгдлийг шийдвэрлэхэд шаардлагатай гэж үзвэл, танд шүүх эмнэлгийн үзлэг хийх санал болгож болно. Та бас өөрийн санаачилгаар, өөрийн зардлаар ийм үзлэгийг хийлгэх боломжтой юм.

Энэ ярилцлагад ч хэлмэрч байдаг. Хэрвээ та хүсвэл VluchtelingenWerk-(ДүрвэгсдийнАжил) байгууллагыг ярилцлагадаа байлгахыг хүсэж болно.

Та энэ ярилцлагын тайланг хүлээж авна.

4 дэх өдөр: гүнзгийрүүлсэн ярилцлагын талаар хэлэлцэх

Таны өмгөөлөгч таньтай гүнзгийрүүлсэн ярилцлагын тайлангийн тухай хэлэлцэнэ. Энэ ярилцлагад ч хэлмэрч өмгөөлөгчийн болон таны хэлсэн болгоныг орчуулж тусална. Хэрвээ тайланд дутуу бичигдсэн болон алдаатай зүйлсүүд байвал өмгөөлөгч бичгээр IND-д мэдэгддэг.

5 дахь өдөр: урьдчилсан шийдвэр

Таныг IND дүрвэгсдийн оршин суух зөвшөөрөл авах нөхцөл байдлыг хангаж буй тухай дүгнэлт гаргана. Энэ дүгнэлтээс гарах шийдвэр нь таны дүрвэгсдийн процедур цаашдаа яаж явагдахыг тодорхойлдог.

Энд дөрвөн боломж бий:

1. Та дүрвэгсдийн оршин суух зөвшөөрөл авах нөхцөл байдлыг хангасан тохиолдолд. Танд (өмгөөлөгчөөр тань дамжуулж) IND захидал өгнө. Энэ захидалд таны дүрвэгсдийн хилийн процедур дуусаж Нидерландын Вант Улсын нутаг дэвсгэрт нэвтэрхийг зөвшөөрсөн байна. Таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөл өмгөөлөгчтэй тань ярилцсаны дараа аль болох хурдан зөвшөөрөгддөг. Та ингээд (түр хугацаанд) Нидерландын Вант улсад үлдэж болно. Өмгөөлөгч танд энэ нь ямар үр дагавар авчрах тухай тайлбарлаж өгнө.
2. IND-д судалгаа явуулахад илүү хугацаа хэрэгтэй байгаа тул 28 хоногийн дотор таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөл шийдвэрлэж чадахгүй гэнэ. IND үргэлжлүүлэн таны дүрвэгсдийн өргөдлийг Дүрвэгсдийн Уртасгасан Процедурээр шийдвэрлэнэ. Энэ процедур нь дүрвэгсдийн (нээлттэй) төвд үргэлжилнэ. Таны дүрвэгсдийн өргөдлийн хариу дараа нь гарна. Та Дүрвэгсдийн Уртасгасан Процедурын талаар тусгай товхимол хүлээн авна.
3. IND таныг дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах болзлыг хангахгүй байх боломжтой байна гэсэн шийдвэр гаргах. Гэвч таны дүрвэгсдийн орогнох хүсэлтийн өргөдлийг тэд Дүрвэгсдийн Ерөнхий процедураар үргэлжлүүлэн шийдвэрлэнэ. Энэ процедур нь голдуу нэг долоо хоногийн дараа дүрвэгсдийн (нээлттэй) төвд эхэлдэг. Та Дүрвэгсдийн Ерөнхий Процедурын талаар тусгай товхимол хүлээн авна.
4. IND таныг дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах болзлыг хангахгүй байна гэсэн шийдвэр гаргах. Та (өмгөөлөгчөөрөө дамжуулан) Дүрвэгсдийн Хилийн процедурын үеэр таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд татгалзах (=төлөвлөгөөтэй) байна гэж бичсэн захиа авна. Энэ захидалд татгалзсан хариу өгөх төлөвлөгөөний шалтгаануудыг дурьдаж танд мөн энэ нь ямар үр дагавар авчрахыг заасан байна. Өмгөөлөгч таньтай уг захидлын талаар хэлэлцэнэ.

6 дахь өдөр: үзэл бодол

Хэрвээ IND таны дүрвэгчийн өргөдөлд татгалзах төлөвлөгөөтэй байгаа бол, та өмгөөлөгчтөйгөө урьдчилсан шийдвэрийн талаар ярилц. Таны өмгөөлөгч таньтай урьд нь энэ талаар ярилцаж тохирсон байх ёстой. Үргэлжлүүлэн таны өмгөөлөгч IND-д бичгээр үзэл бодлоо илэрхийлнэ. Энэ захидалдаа IND-гийн гаргасан урьдчилсан шийдвэрийг албан ёсоор эсэргүүцэж мөн та ямар шалтгаанаар эсэргүүцэж байгаагаа дурдсан байна.

7 ба 8 дахь өдөр: шийдвэр

IND таны илгээсэн үзэл бодлыг уншсаны дараа урьдчилан гаргасан шийдвэрээ өөрчлөх эсэхийг шийддэг. Эндээс гарсан шийдвэр дахиад таны дүрвэгсдийн процедур хэрхэн явагдахыг тодорхойлно. IND гаргасан шийдвэрээ захиагаар танд (өмгөөлөгчөөр тань дамжуулан) мэдэгдэнэ. Таны өмгөөлөгч энэ шийдвэр танд ямар үр дагавартай болохыг тайлбарлаж өгнө. Энд дөрвөн боломж бий:

1. Таныг дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах нөхцөл байдлыг хангаж байна гэж үзэх. Танд (өмгөөлөгчөөр тань

- дамжуулж) IND захидал өгнө. Энэ захидалд таны дүрвэгсдийн хилийн процедур дуусаж Нидерландын Вант Улсын нутаг дэвсгэрт нэвтэрхийг зөвшөөрсөн байна. Таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөл өмгөөлөгчтэй тань ярилцсаны дараа аль болох хурдан зөвшөөрөгддөг. Та ингээд (түр хугацаанд) Нидерландын Вант улсад үлдэн амьдарч болно. Өмгөөлөгч танд энэ нь ямар үр дагавар авчрах тухай тайлбарлаж өгнө.
2. IND-д судалгаа явуулахад (дахин) илүү хугацаа хэрэгтэй байгаа тул 28 хоногт таны орогнол хүссэн өргөгдлийг шийдвэрлэж чадахгүй. IND таны орогнол хүссэн өргөгдлийг цаашид Дүрвэгсдийн Уртасгасан Процедурээр шийдвэрлэнэ. Энэ процедур нь дүрвэгсдийн (нээлттэй) төвд үргэлжилнэ. Таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийн хариу дараа нь гарна. Та Дүрвэгсдийн Уртасгасан Процедурын талаар тусгай товхимол хүлээн авна.
3. IND таныг дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах нөхцөлийг хангахгүй байх боломжтой байна гэсэн шийдвэр гаргах. Гэвч таны орогнол хүссэн өргөдлийг тэд Дүрвэгсдийн Ерөнхий процедураар үргэлжлүүлэн шийдэгдэнэ. Энэ процедур нь дүрвэгсдийн (нээлттэй) төвд үргэлжилнэ. Та Дүрвэгсдийн Ерөнхий Процедурын талаар тусгай товхимол хүлээн авна.
4. IND таныг дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах болзлыг хангахгүй байна гэсэн шийдвэр гаргах. Та (өмгөөлөгчөөрөө дамжуулан) Дүрвэгсдийн Хилийн процедурын үеэр таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд татгалзсан (=шийдвэр) гэж бичсэн захиа авна. Энэ шийдвэрийн хажуугаар тусад нь хариунаас гарах үр дагаварыг зааж, энэ шийдвэрийн эсрэг авч болох арга хэмжээ мөн буцах боломжуудыг тайлбарласан мэдээлэл өгнө. Энэ шийдвэрт мөн татгалзсан хариу өгөх болсон шалтгаануудыг дурьдаж танд мөн энэ нь ямар үр дагавар авчрахыг заасан байна. Өмгөөлөгч таньтай уг шийдвэрийн талаар хэлэлцэнэ.

Анхаар! Дээр дурьдсанаар хилийн процедур нь найман өдөр л үргэлжилнэ. Зарим тохиолдолд, тухайлбал гүнзгийрүүлсэн судалгаа явуулах хэрэгтэй үед IND найман өдрийн дотор шийдвэрлэж чаддаггүй. Тиймээс найман өдрийн хугацаа 28 хүртэл өдрөөр сунгагдах боломжтой байдаг. Тодорхой нөхцөлүүдэд IND хилийн процедурын үеэр таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг удаан хугацаанаар шийдвэрлэх болдог. Хилийн процедурын хүрээнд Бямба, Ням болон баярын өдрүүд нь ажлын өдөрт тооцогддог.

Таныг шаардлагагүйгээр хаалттай дүрвэгсдийн төвд удаахгүйн тулд IND Хилийн процедурыг аль болох хурдан шийдвэрлэх гэж хичээдэг. Таны өргөдлийг Дүрвэгсдийн Хилийн процедураар шийдвэрлэх боломжгүй нь тодорхой болонгуут энэ процедур зогсдог. Тэгээд дараа нь таны өргөдөл Дүрвэгсдийн Ерөнхий болон Уртасгасан процедурт шилжигддэг. Та тэгээд үргэлжлүүлэн нээлттэй дүрвэгсдийн төвд очих болно.

Та ямар тохиолдолд дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах вэ?

Нидерландын Вант улсын Гадаад иргэдийн тухай хуульд ямар болзлууд бүрдэж байж дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авч чадах тухай заасан байдаг. Дараах тохорхойлолтуудын аль нэг нь танд таарч байвал та оршин суух зөвшөөрлийг авч чадна:

- Та арьсны өнгө, яс үндэс, шашин шүтлэг, гарал угсаа, улс төрийн үзэл бодлоос эсвэл ямар нэгэн нийгмийн бүлэглэлд хамаарагддагаас шалтгаалж эх орондоо мөрдлөг хавчлагын аюул заналд учирсан үндэслэлтэй шалтгаантай бол
- Та эх орондоо цаазаар авах ял ба аллагад өртөгдөх, тамлагдаж зовох эсвэл хүнлэг бус эсвэл доромжлогдон гутаагдах аюулд тулгарсан үндэслэлтэй шалтгаантай бол
- Та эх орондоо зэвсэгт мөргөлдөөний хүчирхийллийн улмаас санаандгүй хохирогч болох аюулд тулгарсан ба үндэслэлтэй шалтгаантай бол
- Таны нөхөр/эхнэр, хамтрагч, аав ээж эсвэл насанд хүрээгүй хүүхэд (AMV) тань саяхан Нидерландын Вант улсын дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авсан бол. Таныг өөр бусад дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийн болзол шаардлагуудыг хангаж буй эсэхийг Immigratie- en Naturalisatiedienst (IND) – Дүрвэгсдийн – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага шалгадаг.

Мөн та ямар байгуулгуудтай таарах вэ?



Dienst Terugkeer en Vertrek
Ministerie van Veiligheid en Justitie

Dienst Terugkeer en Vertrek (DT&V) - Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) нь Нидерландын Вант улсын Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яамны харьяа байгууллага юм. Хэрвээ чи татгалзсан хариу авсан бол, чамайг эх орондоо буцах ажлаа зохион байгуулахад DT&V байгууллагын ажилтан тусалдаг.



Internationale Organisatie voor Migratie (IOM) – Олон Улсын Дүрвэгсдийн Төлөөх Байгууллага (IOM) – бол биеэ даасан дэлхий даяар дүрвэгсдэд тусалдаг байгууллага юм. IOM таныг өөрөө сайн дураараа Нидерландын Вант улсыг орхин гарах бол тусалж чадна. IOM таныг буцахад болон дахин эх орондоо эргэн зохицоход тань хэрэгтэй бодит мэдээллийг өгч Нидерландын Вант улсаас явах бэлтгэлээ хангахад тань тусалдаг. Та мөн VluchtelingenWerk – (Дүрвэгчдийн Ажил) байгууллага эсвэл өмгөөлөгчөөсөө тусламж гуйж болно.



Dienst Justitiële Inrichtingen
Ministerie van Veiligheid en Justitie

Dienst Justitiële Inrichtingen (Ministerie van Justitie en Veiligheid) – Шүүх хууль эрхзүй ба Батлан Хамгаалах яам) (DJI) – Хууль эрхзүйн үйлчилгээний байгууллага нь Нидерландын Вант Улсын Шүүх Хууль эрхзүй ба Батлан Хамгаалах яамны харьяа байгууллага юм. Та Хилийн процедурын үеэр энэ байгууллагын хяналтан доор байдаг хаалттай хилийн байранд байх болно.

Танаас юу хүлээж байна вэ?

Дүрвэгсдийн процедурын үеэр та мэдүүлэг өгөхдөө орогнол хүссэн шалтгаанаа сайн тодорхойлон бататгах нь их чухал юм. Мөн танаас бүхий л өөртөө байгаа эсвэл олж авч бүрдүүлж чадах (жишээ нь таны хувийн бичиг баримтууд эсвэл таны мэдүүлгийг батлах захидлууд, гэх мэт) нотлох баримтуудыг IND-д харуулахыг хүсдэг.

IND-д таныг харгалзан авч үзэх хувийн нөхцөл байдал байна уу? Түүнийгээ мэдэгдээрэй. Үүнд чинь үндэслэлд IND ярилцлагын үеэр ч юм уу эсвэл хүлээн авах төвд арга хэмжээ авч чадах юм. IND танд аль болох туслахыг хичээх болно.

Гаргасан өргөгдлөө буцаан татах

Та гаргасан өргөгдлөө хүссэн үедээ буцааж авч болно. Энэ тохиолдолд таныг өмгөөлөгчтэйгөө уулзахыг зөвлөдөг боловч шууд IND-д хандаж ч бас болдог. Хэрвээ та IND-гээ өргөгдлөө буцаан авбал танд энэ улсад өөр шалтгаанаар оршин суух эрх байхгүй л бол Нидерландын Вант улсад байж болохгүй болдог. Та дүрвэгсдийн өргөгдлөө цуцалсныхаа дараа танд дахин шинээр орогнол хүсэх боломж бий.

Дүрвэгсдийн процедурын дараа

Хэрвээ IND таны хилийн дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг тагталвал, та өмгөөлөгчтөйгөө хэлэлцээд Нидерландын Вант улсын шүүгчид энэ шийдвэрийн эсрэг давж заалдаж болно. Энэ нь та шүүгчид IND-гийн гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаагаа албан ёсоор илэрхийлж байна гэсэн үг юм. Та мөн шүүгчээс давж заалдах процедурын үеэр Нидерландын Вант улсад үлдээж өгөхийг асууж болно. Үүнд таны өмгөөлөгч тусалж чадна.

Шүүгч үргэлжлүүлэн IND Нидерландын Вант улсын хуулийн дагуу таны өргөдлийг шийдсэн эсэхийг судална. Ихэнх тохиолдолд та шүүгчийн шийдвэрийг гаргал нь Нидерландын Вант улсад үлдэж хүлээж болдог.

Хэрвээ IND таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг тагталсан бол, таныг өөр хаалттай дүрвэгсдийн төв рүү аваачдаг. Тэнд та Нидерландын Вант улсыг орхин гарах хүртлээ байх болно. Танд мөн Европын ихэнх орнуудын хилээр нэвтрэх хориг тавьсан байдаг. Үүнээс болоод та эдгээр орнуудад үлдэх болон зорчин явах болохгүй болно. Таны эсрэг хилээр нэвтрэх хориг хүчинтэй байсан ч та тагталсан хариуныхаа дараа дахин орогнол хүсэж болно.

Та эх орондоо буцах хариуцлагыг өөрөө хүлээнэ. Dienst Terugkeer en Vertrek (DT&V)- Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) нь таныг буцах үйл ажиллагаанд тусалдаг ба энэ талаар таньтай ярилцдаг. Хэрвээ IND таны дүрвэгсдийн

орогнол хүссэн өргөдөлд тагталсан бол, та эх орондоо хэрхэн буцах тухай товхимол гардан авна.

Хэрвээ та эх орондоо санаачлагаараа буцах хүсэлтэй бол, Internationale Organisatie voor Migratie (IOM)- Олон Улсын Дүрвэгсдийн Төлөөх Байгууллагатай холбоо барьж болно. IOM таныг буцахад тусалж хэрэгтэй мэдээлэл өгнө. Таны дүрвэгсдийн процедур дууссан ч гэсэн та VluchtelingenWerk – (ДүрвэгсдийнАжил) байгууллагаас тусламж болон мэдээлэл авч болно.

Хувь хүний мэдээллийн боловсруулалт

Хувь хүний мэдээлэл бол таны талаарх бүх төрлийн мэдээлэл юм. Энэ товхимолын доор бидэнтэй хамтран ажиллаж буй байгууллагуудын нэрсүүд байгаа. Эдгээр байгууллагууд таны өргөдөл, мэдэгдэл эсвэл хүсэлтийг боловсруулах явцдаа таны хувийн мэдээллийг ашигладаг. Танаас гэд таны мэдээллийг асуугаад хэрвээ шаардлагатай бол бусад байгууллагууд, хүмүүсээс таны талаархи мэдээллийн талаар лавладаг. Эдгээр байгууллагууд таны өгөгдлийг ашиглаад, хадгалж, хуулийн дагуу шаардлагатай бол бусад байгууллагуудад мэдээллийг дамжуулдаг. Хувь хүний нууцлалын тухай хууль тогтоомжинд таны өгөгдлийг боловсруулдаг байгууллагуудын дагах ёстой үүргүүдийг заасан байдаг. Жишээлбэл, тэд таны өгөгдлийг анхааралтай, аюулгүйгээр боловсруулах ёстой. Хувь хүний нууцлалын тухай хуулинд мөн таны эрхийн талаар заасан байдаг, тухайлбал:

- Байгууллагуудаас өөрийн мэдээллийн талаар асууж мэдэх;
- Байгууллагууд таны өгөгдлөөр юу хийдэг, яагаад таны өгөгдлийг хуримтлуулж байгаа гэдгийг мэдэх;
- Цаашлаад ямар байгууллагуудад таны мэдээллийг дамжуулж өгч байгааг мэдэх эрхтэй.

Та өөрийн хувийн мэдээллийн боловсруулалт болон өөрийн эрхийн талаар илүү ихийг мэдэхийг хүсч байна уу? Тэгвэл тухайн байгууллагуудын вэбсайтуудыг судлана уу. Энэ товхимлын доод хэсэгт та тэдгээр байгууллагуудын вэб хаягуудыг олж болно.

Ихэвчлэн тавигддаг асуултууд

Миний анхны IND-д өгөх ярилцлага хэзээ болох вэ?

Танд ирснээ бүртгүүлсний дараа дүрвэгсдийн процедуртаа бэлдэх зургаан өдөр байгаа. Хэрвээ та амрах болон бэлтгэл хангах хугацаагаа богиносгох хүсэлтэй бол өмгөөлөгчтэйгөө ярилцаад IND – д мэдэгдээрэй. Тэгээд та анхны ярилцлагадаа орно.

Би IND-гийн шийдвэр гаргал хир удаан хүлээх ёстой вэ?

Дээр дурьдсанаар хилийн процедур нь найман өдөр үргэлжилдэг. Зарим тохиолдолд, тухайлбал гүнзгийрүүлсэн судалгаа явуулах хэрэгтэй үед IND найман өдрийн дотор шийдвэрлэж чаддаггүй. Тиймээс найман өдрийн хугацаа 28 хүртэл өдрөөр сунгагдах боломжтой байдаг. Тодорхой нөхцөлүүдэд IND хилийн процедурын үеэр таны дүрвэгсдийн өргөдлийн удаан хугацаагаар шийдвэрлэх болдог. Хилийн процедурын хүрээнд Бямба, Ням болон баярын өдрүүд нь ажлын өдөрт тооцогддог.

Мөн IND таны дүрвэгсдийн өргөдлийг үргэлжлүүлж Дүрвэгсдийн Уртасгасан Процедурээр шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд IND таны дүрвэгсдийн өргөдлийг хамгийн ихдээ зургаан сарын дотор шийдэх ёстой. Энэ хугацааг таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд гарын үсэг зурснаас эхэлж тоолно. Та тэгээд Уртасгасан Процедурын тухай шинээр товхимол хүлээж авна.

Хэрвээ IND зургаан сарын дотор шийдэж чадахгүй бол, IND-гээс танд мэдээ ирнэ. Хэрвээ та IND-д дүрвэгсдийн өргөдлөө өгснөөс хойш зургаан сараас илүү хугацаа өнгөрч, танд IND шийдвэрээ явуулаагүй ба IND-гээс мэдээ ирээгүй бол яах вэ? Та тэгвэл IND-ээс бичгээр хоёр долоо хоногийн дотор таны дүрвэгсдийн орогнол хүссэн асуудлыг шийдэхийг шаардаж болно. Өмгөөлөгч тань үүнд тусалж чадна. Таны өмгөөлөгч шүүгчид хандаснаар IND-ээс шийдвэр гаргаагүй удсан хоног бүрээр торгуулийн мөнгө төлүүлэх боломжтой.

Би дүрвэх болсон түүхийг эмэгтэй хүнд ярих хүсэлтэй байна. Энэ болох уу?

Нидерландын Вант улсад та өдөр тутмын амьдралд эмэгтэй, эрэгтэй хүмүүстэй аль алинтай нь харьцахаас зайлсхийх аргагүй юм. Нидерландын Вант улсын нийгмийн тогтолцоонд эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш эрхтэй.

Таныг энэ эрхийг ч бас хүндлээсэй гэж бид хүсэж байна. Хэрвээ та үнэхээр эмэгтэй IND-гийн ажилтантай илүүтэйгээр дүрвэх болсон шалтгааныг ярилцахыг хүсвэл, үүнийг IND-гийн анхны ярилцлаган (= нэгдүгээр ярилцлага) дээр мэдэгдээрэй. IND мөн эмэгтэй хэлмэрчийг гүнзгийрүүлсэн

(= хоёр дахь ярилцлага) ярилцлагын үеэр байлгахыг хичээх болно. Та магадгүй эрэгтэй хүнд дүрвэгчийн түүхээ яримаар байна уу? Үүнийг мөн л IND-гийн анхны ярилцлаган дээр мэдэгдээрэй. IND мөн л гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр эрэгтэй IND-гийн ажилтан ба хэлмэрч байлгахыг хичээх болно.

Хэрвээ би жирэмсэн эсвэл өвдсөн бол юу хийх ёстой вэ?

Хэрвээ та өвдсөн юмуу жирэмсэн бол Онгоцны буудлын Эрүүл Мэндийн байгууллагад хэлээрэй. Мөн эрүүл мэндийн үзлэгт орохдоо сувилагчид мэдэгдээрэй (дээр дурдсанчлан). Та эрүүл мэндийн зөвлөгөөний талаар: Дүрвэгсдийн процедур эхлэхээс өмнө хэмээх товхимолоос уншаарай. Хэрвээ та өөрийгөө сүрьеэ, хамуу, гепатит Б гэх мэтийн халдварт өвчтэй эсвэл та өөрийгөө өвдсөн байх гэж таамаглаж байгаа бол үүнийг хэлэх нь маш чухал юм. Таны сувилагчид ярьсан болгон чинь нууцлагддаг. Таны зөвшөөрөлгүйгээр сувилагч эрүүл мэндийн талаарх мэдээллийг хэнд ч өгөхгүй.

Хэрвээ та дүрвэгсдийн процедурынхаа үеэр өвдвөл IND юмуу VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтангуудад мэдэгдээрэй. Тэд таныг зөв тохирсон (эрүүл мэндийн) тусламж авахад тусална. Хэрвээ та IND юмуу өмгөөлөгчтөйгөө уулзах өдрөө өвдвөл, хамгаалалтын алба юмуу VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтнаас IND-д юмуу өмгөөлөгчдөө таныг өвчтэй байгааг дамжуулж хэлэхийг хүсээрэй.

Энэ товхимолыг уншсаны дараа танд асуух зүйл байна уу?

Танд асуултууд байгаа бол өөрийнхөө өмгөөлөгч, IND юмуу VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтнуудын нэгнээс нь асуугаарай.

Та гомдолтой байна уу?

Бүх дүрвэгсдийн процедуртай холбоотой ажилладаг байгууллууд мэргэжлийн түвшинд, хянамгай ажилладаг. Хэрвээ та үнэхээр ямар нэгэн байгууллага танд муугаар хандсан гэж үзэж байгаа бол, гомдол мэдүүлж болно. Таны өмгөөлөгч юмуу VluchtelingenWerk- (Дүрвэгсдийн ажил) байгууллагын ажилтан танд туслах болно.

Энэ нийтлэлийг хамтран гаргасан:

Дүрвэгсдийн Хүлээн Авдаг Төв Байгууллага (COA) | www.coa.nl

Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) | www.dienstterugkeerenvertrek.nl

Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага (IND) | www.ind.nl

Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар | www.rvr.org

Нидерландын ДүрвэгсдийнАжил байгууллага | www.vluchtelingenwerk.nl

Даалгавраар бичигдэв.

Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яам, Дүрвэгсдийн асуудал хариуцсан захиргааны www.rijksoverheid.nl

Энэ нийтлэлийн агуулгад зохиогчийн эрхийг түгээх боломжгүй. Хэрвээ орчуулгад утга санааны зөрөө гарвал Нидерланд хэл дээрхи нийтлэлийг дагана.